

ЭРДЭНЭ РЕСУРС ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭГ БОЛОВСРУУЛЖ ДУУСЛАА

Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж
2020.06.04

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь Монголын баруун өмнөд хэсэгт орших, өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий ил аргаар олборлох боломжтой Хөндий Алтны Төсөл ("Төсөл")-ийн хараат бус Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ ("БОННУ" буюу "ESIA") - г боловсруулж дууссаныг мэдэгдэхэд таатай байна. БОННУ-г Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("EBRD") – аас тавигддаг Гүйцэтгэлийн Шаардлагын дагуу Sustainability East Asia LLC ("SEA") компани Ramboll Australia Pty Ramboll ("Ramboll") болон Eco Trade LLC ("Eco Trade") компаниудтай хамтран боловсруулсан.

Компани болон ЕСБХБ-ны тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: "Энэхүү хараат бус БОННУ нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, оролцогч бүх талуудад ил тод байхад чиглэсэн Эрдэнэ Ресурсийн үүрэг хариуцлагыг илүү тодорхойлж байна. Энэ тайлан нь Монголд алтны үндсэн ордын хөгжүүлэлт, Баянхонгор аймгийн эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд өндөр ач холбогдолтой Хөндий Алтны Төслийн төлөвлөлтийн хүрээний суурь судалгаануудын нэг юм" хэмээн танилцууллаа.

Эрдэнэ Ресурсийн стратеги, тусгай зөвшөөрөл хариуцсан дэд ерөнхийлөгч Жон Лёнс хэлэхдээ: "Техникийн тайлангуудтай хамтатган БОННУ-г төсөл хөгжүүлэлтийн эрт шатанд танилцуулж байгаа нь төслийн өгөөжийг нэмэгдүүлэх, нөлөөллөөс зайлсхийж, эрсдэлийг бодитоор бууруулах боломжийг бүрдүүлж байна. Монгол Улсын хууль тогтоомжид заагдсан шаардлагууд болон олон улсын стандартуудын дагуу бэлтгэгдсэн БОННУ нь англи, монгол хэл дээр олон нийтэд танилцуулагдаж байгаа бөгөөд оролцогч талуудад хамтын үнэ цэнийг бий болгох Эрдэнэ Ресурсийн төлөвлөгөөг агуулж байна".

ЕСБХБ-ны Байгалийн нөөцийн салбар хариуцсан дарга Эрик Рассмуссен ("Eric Rasmussen"): "ЕСБХБ нь 2019 онд Эрдэнэ Ресурсд хөрөнгө оруулсан бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын нэгэн зорилт нь БОННУ-г боловсруулж 2021 оны сүүлээр Хөндий Алтны Төслийг ашиглалтын шатанд хүргэх байв. Бид энэхүү БОННУ-г төслийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хамгийн өндөр шалгууруудыг хангасан үнэлгээ болсон хэмээн дүгнэж байгаа" гэж онцлов.

Онцлох үр дүнгүүд

Төслийн хараат бус БОННУ-г Sustainability East Asia LLC ("SEA"), Ramboll Australia Pty Ramboll ("Ramboll") болон Eco Trade LLC ("Eco Trade") компаниуд хамтран боловсруулсан. БОННУ нь Монголын хууль тогтоомжид заагдсан үнэлгээ хийх шаардлагуудаас гадна ЕСБХБ-ны Гүйцэтгэгэлийн Шаардлагыг бүрэн хангаж боловсруулагдсан. БОННУ нь нөлөөллийн хүрээ тогтоох, нөлөөллийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг боловсруулах болон нийлмэл нөлөөллийг тооцоолох зэрэг 4 үе шатын дагуу боловсруулагдсан.

БОННУ нь уурхайн бүтээн байгуулалт эхлэхийн өмнө Төслийн үндсэн мэдээлэл, үнэлгээ болон удирдлагын төлөвлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цогц, ил тод байдлаар танилцуулна.

Тайланд тусгагдсан нөлөөлөлд: (1) уур амьсгал ба агаарын чанар, (2) дуу чимээ ба чичирхийлэл, (3) газрын гадарга, газар нутгийн байдал, геологи болон газар хөдлөлтийн төлөв байдал, (4) усны нөөц, (5) биологийн олон янз байдлын хамгаалал, (6) хог хаягдал, (7) хүн ам зүй, (8) эдийн засаг ба хөдөлмөр эрхлэлт, (9) газар ашиглалт, (10) соёлын өв, (11) ажил мэргэжлийн болон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, (12) тээвэрлэлт, (13) нийлмэл нөлөөлөл зэрэг нөлөөллүүдийг багтаасан.

Нөлөөллөөс зайлсхийх, бууруулах талаар удирдлагын авч хэрэгжүүлэх шаардлагатай үүрэг хариуцлага нь төлөвлөгөөнд цогц байдлаар тусгагдсан. Эрдэнэ Ресурсийн хувьд Хөндий Алтны Төслийг салбарын тэргүүлэх жишигт нийцүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааны суурь элемент болсон БОННУ-ний Удирдлагын Төлөвлөгөөнд дараах зүйлс орж байна:

- > Уур амьсгал ба агаарын чанар
 - Уурхайн ажилчдад учрах агаарын чанарын эрсдэлийг бууруулах дэд бүтцийн шийдлүүд, тоосжилт болон авто замын хяналт ажиглалт, мөн гэрээт гүйцэтгэгчдийн хяналт багтаж байна.
- > Дуу чимээ ба чичирхийлэл
 - Дуу чимээ, чичирхийллийг бууруулахад чиглэсэн тоног төхөөрөмж, барилга байгууламжийн загвар, үзүүлэлтийн шийдлүүд
- > Усны нөөц
 - Боловсруулах үйлдвэрт ашигласан усны 80%-ийг дахин боловсруулж, ашиглах замаар ус ашиглалтын үр ашгийг хамгийн их байлгах.
 - Орон нутгийн оролцогчид, малчдын оролцоотойгоор усны нөөцийн ажиглалт, хяналтыг гүйцэтгэх
 - Нөөц худгуудаас гадна Төслийн талбайн ойр орчмын улирлын чанартай усыг ашиглах шийдлүүд
- > Биологийн олон янз байдлын хамгаалал
 - Төслийн талбайн газар ашиглалтын өмнөх судалгаа, ургамал болон ан амьтанд нөлөөлөх тухайн бүс нутгийн шууд бус нөлөөллийн байнгын болон хамтарсан ажиглалт хяналт
- > Хаягдал
 - Хаягдлын боловсруулалт, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, энгийн аюулгүй хаягдлын зүй зохистой устгалыг хангахад чиглэсэн хаягдлын инженерчлэгдсэн удирдлага, дамжуулах талбай болон хаягдал ус боловсруулах үйлдвэр
 - Хаягдлын Нэгдсэн Байгууламж (“ХНБ”) нь боловсруулах үйлдвэрийн ба хүдрийн хаягдлыг нэг овоолгод хадгалах замаар уурхайн хаягдал чулуулгийг тусгайлсан байгууламжид устгах, ингэснээр уурхайн ашиглалт болон хаалтын үеийн байгаль орчин, газар эвдрэлийн эрсдэлийг бууруулах,
- > Аюултай материал
 - Олон Улсын Цианидийн Удирдлагын Кодын зарчим ба зааварчилгаа мөн үндэсний холбогдох стандартын шаардлагуудыг дагаж мөрдөх үйл ажиллагаа
- > Гэрээт гүйцэтгэгч ба ханган нийлүүлэлт
 - Төслийн бүх ханган нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчдийг хамруулан үйл ажиллагаандаа сайн засаглал, ёс зүйн үзэл баримтлалыг хэрэгжүүлж ажиллах
 - Орон нутгийн ханган нийлүүлэх боломжийг судлан үнэлж, орон нутгийн ханган нийлүүлэлтийг дэмжин хөгжүүлэх.
- > Осол ба онцгой байдлын хариу арга хэмжээ

- Төслийн талбай дахь эмнэлгийн яаралтай тусламжийн нэгж мөн бүх ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчдэд зориулсан байнгын бэлэн байдлын сургалт
- > Хүний нөөц
 - Төслийн хамаарах бүсэд ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчдийн дагаж мөрдөх дарамтаас ангид байх бодлого мөн сахилга батын дүрэм журмыг оруулаад ажлын байрны төрөл бүрийн дарамтын эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүд
 - Ажлын байран дээрх сургалт мөн ойр орчмын сумдын төвийн иргэдэд ажил мэргэжилд суралцахад нь дэмжлэг үзүүлэх замаар орон нутгаас ажиллах хүч түлхүү авах
- > Газар ашиглалт ба амьжиргаа
 - Төслийн тусгай зөвшөөрөлтэй бүсэд малчдын хуучин болон одоо ашиглагдаж буй хашаа хороо байхгүй
 - Үндэслэлтэй шаардлага тавьж буй орон нутгийн малчдад учирч болох эдийн засгийн болон бусад чирэгдэл бэрхшээлүүдийг эрт илрүүлэх, тэдгээрийг уламжлалт амьжиргаа, байгалийн баялгийн менежмент болон ур чадварыг нь дэмжин дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг ашиглан удирдах
- > Ажил мэргэжлийн болон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал
 - Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд оролцогч талуудын хамтаар орон нутгийн нийтийн эрүүл мэндийн санал санаачилгад стратегийн дэмжлэг үзүүлэх
 - Талбайн аюулгүй байдлыг хангах нэгдсэн нэвтрэх болон хяналтын систем
- > Оролцогч талуудын оролцоо ба харилцаа
 - Эрдэнэ Ресурс компанийн зүгээс материаллаг мэдээллийг Англи болон Монгол хэлээр боловсруулдаг байдал тулгуурлан харилцаа холбоо, мэдээлэл солилцооны харилцан хүлээн зөвшөөрсөн, хүртээмжтэй талбаруудыг бий болгох
 - Санал зөвлөмж, гомдлын мэдээлэл, харилцааны эргэх холбоо бүхий механизмыг бий болгох
- > Орон нутгийн хамтын ажиллагаа
 - Баянхонгор аймаг болон Шинэжинст, Баян-Өндөр сумдад боловсрол, эрүүл мэнд болон байгаль орчны менежментийг дэмжих зорилгоор орон нутгийн удирдлага болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах, түншлэлээ өргөтгөх
 - Соёлын өвийг дэмжих зэрэг орон нутгийн хамтын ажиллагааны өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгцээнд тулгуурласан, оролцоог хангасан төлөвлөлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- > Тээвэрлэлт
 - Гэрээт болон туслан гүйцэтгэгчдийг хамруулаад бүх талбайн болон тээврийн замын маршрутыг урьдчилан тодорхойлж хөдөлгөөний хяналтыг хатуу мөрдөх
- > Газрын эвдрэлийн хяналт ба нөхөн сэргээлт
 - Газрын эвдрэл гарахаас өмнөх судалгаа, тохиолдлын судалгаанд тулгуурласан хяналт
 - Унаган ургамлыг нөхөн тариалах үйл ажиллагааг багтаасан дэвшилтэт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- > Уурхайн хаалт
 - Уурхайн хаалтын төлөвлөлт болон гүйцэтгэлийг Төслийн стандарт шаардлагад нийцүүлэх, төлөвлөгөөний дагуу ажлуудыг гүйцэтгэхийн тулд хаалтын бодлого зорилтыг эрт тодорхойлох

Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ (“ESIA”) – ний тайлан болон түүний Техникийн Бус Хураангуйг Компанийн цахим хуудаснаас дараах холбоосоор авч танилцах боломжтой:

БОННУ (Англи): https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA

Техникийн Бус Хураангуй (Англи): https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA_Non-Technical_Summary

БОННУ (Монгол): https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA_mon

Техникийн Бус Хураангуй (Монгол): https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA_Non-Technical_Summary_Mon

ЕСБХБ-ны шаардлагад нийцсэн Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ (“ESIA”) - ний үр дүнгүүдийг харгалзан Eco Trade компани Баян Хөндий төслийн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (“DEIA”)-г Монгол Улсын холбогдох стандартын дагуу боловсруулж байна. Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (“DEIA”) –ний олон нийтийн хэлэлцүүлэг 2020 оны дундуур хийгдэхээр төлөвлөгдсөн. Хэлэлцүүлгийн дараа Компани Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (“DEIA”) -г батлуулахаар Монголын Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд хүргүүлнэ.

Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардагас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй [эндээс танилцана уу](#)) танилцуулсан бөгөөд энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (“NPV5%”) (алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлөхөд) тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр 42%, 90% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮд 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилүүдэд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 48,000 унц алтыг олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусгах технологийн боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани нь төслийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлж байна.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд COVID-19 вирусний тархалтаас үүсэх компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох нөлөөлөл, гуравдагч талын зөвшөөрлийг авах, эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>